

Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын
2021 оны 6 дугаар сарын үйл ажиллагааны тайлан

2021 оны 6 сарын 24-ны өдөр

Төрийн удирдлагын чиглэлээр:

Зургаадугаар сард 202 албан бичиг бүртгэгдсэн бөгөөд үүнээс хугацаатай 47 албан бичгийг хугацаанд нь холбогдох албан тушаалтан, байгууллагад хүргүүлсэн.

Гүн худагтай холбоотой -3, гэр хүссэн-1, хашааны банз хүссэн -1, блок хүссэн-1, ажлаас чөлөөлөгдөх хүсэлт-1 тус тус өргөдөл, гомдол ирүүлж, нийт 43 иргэний өргөдлийг бүртгэлд хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Удирдлагын баримт бичгийн хувьд сумын Засаг даргын “А” захирамж – 186 батлагдсан бөгөөд хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

2021 оны 06 дугаар сарын байдлаар шинээр төрсөн -80, үүнээс эрэгтэй – 27, эмэгтэй-53, ургийн овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл-3, үрчлэлт-2, нас барсан-26 үүнээс эрэгтэй-7, эмэгтэй-19, гэрлэсний бүртгэл-36, цахим иргэний үнэмлэх захиалсан– 40, цахим иргэний үнэмлэх сунгалт хийлгэсэн– 25, 45 насны- 90, эцэг, эх тогтоолгосны бүртгэл – 10 тус тус бүртгэгдсэн байна.

Лавлагаа, гэрчилгээ дахин олголт:

А4 лавлагаа –15(үйлчилгээний хураамж – 75000 төг)

А5 лавлагаа – 16 (үйлчилгээний хураамж – 16000 төг)

Төрсний гэрчилгээ – 3 (үйлчилгээний хураамж – 15000 төг)

Нийт: 106000 төгрөг

Иргэний шилжилт хөдөлгөөн:

Аймаг, хотоос шилжин ирсэн –насанд хүрэгч – 1 /насанд хүрээгүй 3, үйлчилгээний хураамж 3500 төг /Сум, дүүрэгт шилжин ирсэн –5 (насанд хүрээгүй 4, үйлчилгээний хураамж – 12500 төг) Баг хооронд шилжин ирсэн – 1 (үйлчилгээний хураамж – 2500 төг) Мөнгөний баримтыг иргэдээс авч архивлан хадгалж байна.

Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотойгоор иргэний шилжилт хөдөлгөөнийг 04 сарын 10-нд зогсоох талаар иргэдэд цахимаар мэдээлэл өгч, хуулийн хугацаанд бүртгэлийг түр зогсоон, үнэт цаасыг битүүмжлэн, бүртгэлийн дэвтэрт тэмдэг дарж, баталгаажуулсан.

Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд заасан заалтын дагуу сонгуулийн байгууллагад ажиллах 24 иргэний сонгогч шилжих материалыг бүрдүүлэн хуулийн хугацаанд хэлтэст хүргүүлсэн.

06 сарын 09-нд хэлтэс рүү мэдээг нэгтгэн явуулж, иргэний бүртгэлийн ирц бүртгэлийн тоног төхөөрөмжийг бүрэн бүтэн хэлтэст хүлээлгэн өгсөн.

Хугацаатай албан бичиг:

2020 оны төрсний бүртгэл, овог, эцэг\эх\-ийн, өөрийн нэр өөрчилсний бүртгэл, гэрлэлтийн бүртгэл, нас барсны бүртгэл нийт 4 төрлийн бүртгэлийн дэвтрийг хавтаслан 01 сарын 10-нд архивт тушаав.

ХАСХОМ-ийг 01 сарын 11-нд цахимаар үнэн зөв бөглөн, 11-нд баталгааны хуудсыг баталгаажуулан бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн. Төрийн нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хууль тогтоомжийг мөрдөж ажиллах тухай нууцын баталгаа гарган 01 сарын 11-нд хэлтэст хүргүүлсэн.

Ерөнхийлөгчийн сонгуулийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Хэсэг байгуулах тогтоолыг хэлтэс рүү хуулийн хугацаанд хүргүүлсэн. Хүн ам, өрхийн мэдээллийн санд бүртгэлтэй түр оршин суугчдын судалгааг гаргах зорилгоор Багийн засаг дарга нараас судалгаа авахад бүртгэлтэй түр оршин суугч байхгүй тул хэлтсийн ахлах бүртгэгчид мэдэгдсэн. Иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтны судалгааг хэлтэст хүргүүлэн ажиллаж, гэрээ болон нууцын баталгааг заасан хугацаанд хэлтэст хүргүүлсэн. Сар бүрийн 24-нд иргэний бүртгэлийн мэдээ, үнэт цаасны тайлан, орлогын мэдээ, лавлагааны мэдээг хэлтэст хүргүүлэн ажиллав.

2021 оны 03 сарын 05-нд “Уулбаян сумын Улсын бүртгэл” цахим бүлэг нээн ажиллуулж байна. Одоогийн байдлаар 109 гишүүнтэй, 23 төрлийн мэдээг давхардсан тоогоор 847 иргэн танилцсан. Уулбаян сум Сүхбаатар аймаг фэйсбүүк групп дээр иргэний шилжилт хөдөлгөөн, цахим үнэмлэхээ хуулийн хугацаанд сунгуулах талаар заавар зөвлөгөөг хүргэж ажиллав. Цахим сүлжээнд орох боломжгүй иргэдэд Засаг даргын тамгын газрын урсдаг самбараар мэдээлж байна.

Цахим үнэмлэхний сунгалт, шинээр цахим үнэмлэх авах иргэд хуулийн хугацаанд ирж сунгалтаа хийлгэхгүй байгаа учир Хүн ам, өрхийн мэдээллийн сангаас 2005, 1996, 1976 онд төрсөн иргэдийн судалгааг авч, утсаар холбогдон хугацаандаа ирж цахим үнэмлэхээ захиалахыг зөвлөн ажиллаж байна. Энэ аргыг нэвтрүүлснээр 42 иргэн цахим үнэмлэх захиалснаас 2 иргэн торгууль төлсөн. Дээрх 2 иргэн нь Хэнтий болон Баруун-Урт сумын

иргэд болно. Шинээр томилогдсон 4 багийн засаг даргад хууль эрх зүйн мэдээлэл өгөхөөс гадна гарын авлага бэлтгэн мэдээ мэдээллээр ханган ажиллав. Цахим орчинд иргэний шилжилт хөдөлгөөн, E-Mongolia.mn апп ашиглах заавар, сонгогчийн нэрсийн жагсаалт тулгах гэх мэт цаг үеийн мэдээллүүдийг иргэдэд түгээсэн.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Сумын хэмжээнд коронавирусын халдвар хамгааллын дэглэмийг сахиж ирлээ. Сум тойрсон хөдөлгөөнт эргүүлийг 50 хоногийн хугацаанд /өдрийн 1 машинд 15л шатахуун/, тэгш багт өвчлөл гарсан айлд хяналт тавихад зориулж 3 газарт 6 төрийн албан хаагч 3 машин тус тус гарч 1 машинд 40 л шатахуун, өдрийн 4 машин гарч нийт 15030,0 мянган төгрөгийн шатахууны өр үүсээд байна. Халдвар хамгааллын хувцас, ариутгалын бодис, 5200,0 төгрөгийн зардал гарч, 4700,0 мян төгрөгийн нөөцийг бүрдүүлээд байна. Тусгаарлах байрны бэлэн байдлыг ханган Улсын онцгой комиссын 31 дугаар тушаалын дагуу тусгаарлан ажиглах байрны шаардлагыг ханган ажиллаа.

Төсвийн орлогын талаар:

№	Төрөл зүйл	Жилийн т-гөө	6 сар		хувь
			Т-гөө	Гүйц	
	Нийт орлого	138340,0	68524,3	46272,6	67,5%
1	Татварын орлого	53340,0	23024,3	40778,1	177,1
	Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар	25000,0	12498,0	16226,5	
	Хөрөнгө борлуулсны орлого	15000,0	7500,0	10744,6	
	Үйл ажилллагааны орлого	1200,0	600,0	720,6	
	Бууны албан татвар	1140,0			
	Улсын тамдэгтийн хураамж	2000,0	996,0	1364,9	
	Хог хаягдлын хураамж	3000,0	1430,3		
	Малаас суутгасан албан татвар			6258,5	
	Газрын төлбөр	6000,0		5463,0	
2	Татварын бус орлого	85000,0	45500,0	5494,5	12%
	Хүү торгуулийн орлого	15000,0	7500,0	5494,5	
	Нэр заагдаагүй бусад орлого	70000,0	38000,0		
3	Аймгаас ирэх Санхүүгийн дэмжлэг	470290,2	251838,7	232263,7	-19595,0
4	ТЗШ-ийн санхүүжилт				

Тайлбар: Нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Эм эл цахиурт овоо ХХК-аас хамтарсан гэрээний дагуу 2019-2020оны 50,0 сая төгрөг орох ёстойгоос орлого ороогүй тул орлогын төлөвлөгөө тасарч харагдаж байна. Ковид цар тахалаас болж аймгийн орлого тасарч байгаа тул аймгаас ирэх санхүүгийн дэмжлэг 19595,0 мян төгрөг дутуу ирж зарлага тээвэр шатахуун, шуудан холбооны зардлыг 50 хувь бууруулан санхүүжүүлсэн байна. МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд хэсгийн хороонд ажилласан иргэдийн хоол урамшуулалын зардлаас ХХСОАТ-т 2177,0 мян төгрөг орж нийт татварын орлогын хэмжээ 177,1 хувиар биелэсэн байна.

Төсвийн байгуулагууд эхний хагас жилд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж өр авлага үүсгэлгүй ажиллаж ирлээ. Цэцэрлэг нь НДШ-ийн 3,0 сая гаруй төгрөгийн өртэй байсныг 6-р сард төлж барагдуулсан байна. Ковид-19 цар тахалаас үүссэн эргүүл постын шатахууны өр 12,0 сая төгрөгийг ТГ-ын хэмнэгдэж байгаа албан томилолт, урсгал засварын зардлаас 3,3 сая төгрөгийг, төсөвт байгууллагын /сургууль цэцэрлэг/ гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардлаас 4,0 сая төгрөгийг, хуучин өвс худалдан борлуулсан орлогоос 2,6 сая төгрөгийг тус тус зарцуулан шатахууны өрийг барагдуулж байна.

Төсвийн байгууллагын зарлага

№	Зардлын нэр төрөл	Төл-гөө	Гүйц
1	Цалин	794937,3	728997,6
2	НДШ	107253,6	90675,5
3	Бусад зардал	766117,2	502104,1

Тайлбар: нийт төсвийн 54,1 хувийг цалин НДШ эзлэж байна. Сургууль цэцэрлэгийн ажилчдын ээлжийн амралтын мөнгийг бүрэн олгосон. Ковид-19 цар тахалаас үүдэж сургууль цэцэрлэгийн хүүхэд танхимаар хичээллээгүй тул хоолны зардлыг олгоогүй, МУ-ын ЗГ-ын 43 дугаар тогтоолоор төсөв байгууллагын зардлыг хэмнэсэн. Тусгаарлах байрны бэлэн байдлыг ханган 5,2 сая төгрөгийн халдвар хамгааллын хувцас ариутгалын бодис нөөцлөөд байна.

Худалдан авах ажиллагааны талаар

- Нийтийн халуун усны цахим тендерийг зарлаж тендерт 2 компани материалаа ирүүлээд байна.
- Замын хойт талд байгаа 4 айлын газар чөлөөлөх комисс томилж иргэдийн газрыг чөлөөлөх гэрээ байгуулан иргэдэдтэй зөвшилцөв.
- Жишиг хороололын ундны усны худагт автомат төхөөрөмж /ухаалаг худаг/ байгуулах гэрээг хийж гүйцэтгэв.
- Чийрэгжүүлэлтийн танхим байгуулах тендерийн баримт бичгийг боловсруулж цахимаар зарлаад байна.
- Жавхлант багийг өндөр хүчдэлд холбох төсвийг мэргэжилийн байгууллагаар хийлгүүлээд байна. Энэ сардаа багтаагаад цахимаар тендерийг зарлана.

Бусад ажлын талаар

МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн хэсгийн хороо, сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулж 28515,0 мянган төгрөгийн зардал гарч санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагад хүргүүлээд байна.

Хага жилийн мал тооллогын ажлыг сумын засаг даргын тоот захирамж гарч 111 малчин өрхийг түүвэр судалгааны аргаар тоолж багийн засаг дарга нарт сургалт зохион байгуулан түүвэр суалгааны асуулга, малын программын шивэлтийг хийж дүнг тушааж байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Байгаль хамгааллын чиглэлээр:

Хог хаягдлын чиглэлээр

Хогийн нэгдсэн цэгийн түрэлтийн ажлыг уул уурхайн Сун-Хун голд ХХКомпаний ковш, хово зэрэг тээврийн хэрэгсэлийг ашиглан хог цэгийн түрэлтийн ажлыг 2 хоног хийж гүйцэтгэлээ. Мөн сумын өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор иргэдийн орон байран дах хуримтлагдсан элсийг үнэ тохирч түрж цэвэрлэсэн. Хуримтлагдсан мөнгөн хөрөнгийг тээврийн хэрэгслийн шатахуунд зарцуулсан. Байгаль хамгаалах сангаас шатахуунд нийт 800л зарцуулагдсан.

Бүх нийтийн цэвэрлэгээний ээлжит ажлийг 2021 оны 6.2ны өдөр хийж гүйцэтгэлээ. Цэвэрлэгээнд ААН байгууллага иргэд оролцон сумын төвийн өнгө үзэмжийг сайжруулах

зорилгоор нийтийн эзэмшлийн талбай, булгийн эх зэрэг талбайг цэвэрлэсэн. Тээврийн хэрэгслийн зардалд байгаль хамгаалах сангаас шатахуунд 30л зарцуулагдсан.

Усны чиглэлээр

Сумын төвийн жишиг хорооллийн худаг ухаалаг төхөөрөмжтэй боллоо. Худгийг хүлээн авах ажилд гар бие оролцон цаашид хариуцан ажиллаж байна.

Бусад ажлын чиглэлээр

Нягтлан бодогчоор ахлуулсан баг бүрэлдэхүүн Уулбаян сумын 3-р багийн сонгуулийн хэсгийн хороонд ажиллаа.

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор сумын төвийн орох гарах хөдөлгөөнийг хязгаарлах ажилд гар бие оролцон ээлжит постонд гарсан.

Иргэдийн гомдол мэдээлсэний дагуу холбогдох мэргэжилтэнгүүдтэй очиж асуудлыг шийдвэрлэсэн.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

ХАА-1 мэдээг цаг тухай бүрд нь илгээв. Сумын хувьд 106959 хээлтэгчээс 93620 нь буюу 87.5% нь төллөөд байна. Үүнээс ингэ-174, гүү-4606, үнээ-4606, эм хонь-54201, эм ямаа- 30033 төллөөд байна. Нийт 93626 төл хүлээж авснаас төлийн бойжуулалт 100%-тай байна.

ХАА-2 мэдээг цаг тухай бүрд илгээв. 2021 оны 6 сарын байдлаар Том малын зүй бус хорогдол 363 /толгой/ гарсан байна.

Хүнс, худалдаа, үйлчилгээ чиглэлээр:

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний бодит нөөцийн судалгаа 2021 оны 6 сарын 20 байдлаар.

Бүтээгдэхүүний нэр	Нөөц
Гурил	13 тн
Гурилан бүтээгдэхүүн	454 ш
Будаа	520 кг
Хуурай/Шингэн сүү	350ш
Өндөг	760ш
Ургамлын тос	291ш
Төмс	960кг

Хүнсний ногоо	140кг
Элсэн чихэр	545кг
Давс	243кг
Савласан ус	380ш

№	Байгууллагын нэр	А-80	А-92	ДЗ
1	“Байшинт Ойл” ХХК	15тн 800л	8тн 500л	11тн 300л

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн судалгааг 4-5сартай харьцуулан харуулав.

№	Бүтээгдэхүүний нэр		2021 оны 5 сарын 25 байдлаар	2021 оны 6сарын 17 ны байдлаар
1	гурил	Дорнод дээд	35000	36000
		УБ 1-р зэрэг	36000	37000
		Дорнод 2-р зэрэг	29000	29500
2	Цагаан будаа		2500	2500-2800
3	Шингэн сүү		3500	3500-3700
4	Хуурай сүү		5000-9500	5000-10500
5	Элсэн чихэр		2500	2500-2800
6	Ургамлын тос		4800	4800-5200
7	Өндөг		700	750
8	Төмс		1800	1500
9	Хүнсний ногоо	Сонгино	2000	2500
		Байцаа	2000	2600-2800
		Лууван	2000	2500
		Сармис	2500	2500
10	Давс		1000-1100	1000-1500
11	Савласан ус		600-3500	600-4000

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэхгүй байхыг 2021оны 4сарын 11 өдөр аж ахуйн нэгж, худалдаа үйлчилгээ эрхлэгч нарт мэдэгдэл хүргүүлж, хууль тогтоомж зөрчих, мэдэгдлийн хэрэгжилтийг хангахгүй зөрчил гаргавал Зөрчлийн тухай хуулийн дагуу 5.13 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага оногдуулахыг мэдэгдсэн.

Коронавируст халдвар цар тахлын батлагдсан тохиолдол гарсантай холбогдуулан өндөржүүлсэн бэлэн байдлын үед халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөж, олон нийтийн газраар зорчихдоо хүн хоорондын зай барин, гар ариутгагч хэрэглэх, амны хаалтаа тогтмол зүүх, үйлчлүүлэгчийн биеийн халуун үзэж тэмдэглэх, өдөр тутмын цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх зэрэг халдвар хамгааллын дэглэмийг мөрдлөгө болгон ажиллахыг үйлчилгээ эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгж байгууллагад 7 хоногт 2-3 удаа зөвлөмж, зөвлөгөө өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

2021 оны 06 сарын 1-ны өдөр Хүүхдийн баярын өдрийг тохиолдуулан хүнсний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр хүнсний худалдаа үйлчилгээ, эрхэлдэг 5 дэлгүүрийн худалдан боловсруулж буй хүнсний бүтээгдэхүүний гарал үүсэл, жор орц, хадгалах хугацаа, хаяг шошго, сав баглаа боодолд хяналт хийн. Холбогдох хууль, стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг танилцуулан мэдээлэл, зөвлөгөөг өгч ажилласан.

2021 оны 06 сарын 22-ны өдөр Хүнсний хадгалалт, тээвэрлэлт, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд шалгалт хийж, хүнсний аюулгүй байдлыг хангуулах, коронавируст халдвараас урьдчилан сэргийлж, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахин, хоол хүнсээр дамжих хордлого, болзошгүй эрсдэлээс сэргийлэх мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмж, зөвлөгөөг хүргэн ажилласан.

Бусад ажлын хүрээнд

1. Гэрийн ажиглалтад байгаа иргэдэд хяналт тавих ажлын хэсэгт ажиллаж байна. Халдвартай бүс нутгаас ирж байгаа иргэдийг гэрийн ажиглалтад 7 хоног байлган мэргэжлийн байгууллагаас өгсөн зөвлөмж зөвлөгөөг хүргэн, хяналт тавин ажиллаж байна. Гэрийн ажиглалтад ирэх иргэнийг хүлээн авч, холбогдох шийдвэр заалтуудыг хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн баталгааны хуудсыг гэр бүлийн гишүүд, иргэдтэй хамтарч байгуулан ажиллаж байна. Иргэд, гэр бүлийн гишүүд зөрчил гаргасан мөн зөвлөмжийг дагаж мөрдөөгүй тохиолдолд хууль тогтоомжид заасан хариуцлага тооцохыг анхааруулан ажиллаж байна. Өдөр бүр 14:00-17:00 цагийн хооронд гэрийн ажиглалт, тусгаарлалтад байгаа иргэдэд хяналт тавьж, ажилласан мэдээ илтгэх хуудасыг аймгийн мэргэжлийн хяналтын газрын хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчид явуулдаг.

2021.06.22-ны байдлаар 2011-2020оны хооронд зээл авсан 30 зээлдэгчийн 248,800,000 төгрөгийн зээл олгосон байна. Бодогдсон хүү нь 13,627,342 төгрөг. Үүнээс, зээлийн хүү, алданги ороод 115,442,314 төгрөг эргэн төлөгдсөн. Нийт үлдэгдэл 146.625.028 төгрөг байна.

2021оны 06сарын 23-ны байдлаар зээлийн ангилалаар авч үзвэл:

- Хэвийн зээлтэй- 13 зээлдэгчийн 88,000,000 төгрөг,
- Эргэлзээтэй зээлтэй /181-360хоног/- 5 зээлдэгчийн 47,000,000 төгрөг
- Муу буюу чанаргүй зээлтэй /360≥/- 11 зээлдэгчийн 131,800,000 төгрөг
- 3 зээлдэгчийн 48,287,470, төгрөг эргэн төлөгдөж хаагдсан.

2.1.1. Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлт

- 5 сарын 31 байдлаар зээлийн эргэн төлөлтөөр 5,777,000,00 төгрөг сум хөгжүүлэх санд орж ирсэн байна.

2.1.2. Эргэн төлөлт хийхгүй байгаа 3 зээлдэгч:

Зээл авсан он		Зээлдэгч	Зээлийн дүн
1	2019.05.25	Л.Мөнхнаст	9,000,000
2	2020.5.27	Э.Эрдэнэтуяа	5,000,000
3	2019.05.25	Б.Сэрчмаа	10,000,000

Барьцаа хөрөнгийн асуудалтай 1 зээлдэгч:

- 2013 онд зээл авсан - Ж.Мөнхтуул

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлэх 1 зээлдэгчид:

- 2016 онд зээл авсан - С.Шарав

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт байгаа 3 зээлдэгчид:

- 2013 онд зээл авсан - Л.Эрдэнэхуяг, Г.Мөнхтулга, Г.Галбадрах,

2.1.3. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зориулан хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулалтийг

2021оны 6 сарын 22 өдрөөс 7сарын 5-ны өдөр хүртэл хүлээн авах мэдээллийг Уулбаян сумын албан ёсны мэдээ мэдээллийн групп, Уулбаян сум гэсэн мэдээллийн нэгдсэн групп хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэсэн.

Мал эмнэлэгийн чиглэлээр:

2021 оны 05 сарын 25 ны өдөр сумын мал эмнэлгийн тасаг, эрүүл мэндийн төвтэй хамтран сумын төвийн 150 гаруй нүхэн жорлон муу усны нүхэнд халдваргүйтгэлийн арга хэмжээ зохион байгуулсан. Аймгийн мал эмнэлгийн газрын 2021 оны 05 сарын 18 ны өдрийн №18 тоот зөвлөмжийг хүлээн авч 2021 оноос малын эмч нарын үйлчилгээний хөлсний нэхэмжлэлийг татварын албанд бүртгүүлж “Э” баримт бүрдүүлж олгох болсонтой холбогдуулан хувийн хэвшлийн малын эмч нарт татварын албанд бүртгүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээний хөлсийг цахим системтэй тулгалт хийж олгох талаар мэдээлэл өгч ажиллаа. Тус аймгийн хилийн сумдад малын гоц халдварт шүлхий өвчин оношлогдсонтой холбогдуулан тус суманд отроор ирсэн Өвөрхангай аймгийн Гучин ус сумын 4 өрхийн малыг вакцинд хамруулж, тарилгын ажилд хяналт тавин ажилласан Мөн баруун бүс, говийн бүс, төвийн бүсийн уралдаанд оролцох, шилжилт хөдөлгөөн хийгдэх зэрэгт заавал ийлдсийн шинжилгээ авч гарал үүслийн гэрчилгээ олгох ажил хийгдэж эхлээд байна.

2021 оны 05 сарын 27 нд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд хамрагдах /өвчлөмтгий/ бүх малын тоог гарган аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлсэн. 2021-06-02 нд Мал эмнэлгийн өрөнхий газраас зохион байгуулсан цахим сургалтанд мал эмнэлгийн тасаг, хувийн хэвшлийн малын эмч нар бүрэн хамрагдсан. Мал эмнэлгийн өрөнхий газрын даргын А/73 тоот тушаалаар малын гоц халдварт шүлхий өвчний тандалт шинжилгээ хийх ажил батлагдсантай холбогдуулан тандалтанд хамрагдах өрх, малын судалгааг аймгийн мал эмнэлгийн газарт хүргүүллээ. Мал эмнэлгийн өрөнхий газраас 2021 оны 06 сарын 15 нд зохион байгуулсан малын халдваргүй өвчний цахим сургалтанд мал эмнэлгийн тасаг, малын эмч нарыг бүрэн хамруулсан бөгөөд сургалт цаг үеэ олсон үр дүнтэй санагдсан. Тайлант сард аймгийн Мал эмнэлгийн газарт малын хорогдол, мал амьтны хүүр сэг зэм устгал, халдваргүйтгэлийн мэдээ, Ковид-19 өвчний мэдээг 3 удаа, мал эмнэлгийн улсын байцаагчийн тоон тайланг 3 удаа хугацаанд нь хүргүүлсэн. Тайлант сарын хугацаанд сумын Засаг даргын тамгын газар, аймгийн Мал эмнэлгийн газраас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажилласан.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт:

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 12 иргэнтэй сар бүр холбогдож эргэн төлөлтийг хийлгэж байна.

2021 онд малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдах шаалгуур хангасан малчдын судалгааг гаргасан .

Төсөл хөтөлбөрүүд зарлагдсантай холбогдуулан сумын групп болон 5 багийн даргад мэдээлэл өгөн 9 иргэний төслийг хүлээн авч сумын АДЗ-өөр хэлэлцээд байна.АДЗ-ийн гишүүдэд төсөл хөтөлбөрүүдийн танилцуулга мэдээллийг хийсэн.

Малжуулах арга хэмжээнд хамрагдах өрхүүдийг сумын АДЗ-өөр оруулан 1 өрхийн материалыг хүргүүлээд байна. Мөн нийтийг хамарсан ажлын төслийг ХХҮГ-т хүргүүлсэн НХА,малжуулах арга хэмжээ цар тахлаас болоод түр хойшлоод байна. Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт Э.Гантөмөр “Тар утас засвар үйлчилгээний” төсөл дэмжигдсэн байна. Цар тахалын буюу COVID19 үед тэг зогсолттой байсан тул, Аймгийн онцгой комисс, Улаанзагалмайтай хамтран 30 өрхөд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлсэн .

Нийгмийн халамжийн чиглэлээр:

Сумын амьжиргааг дэмжих зөвлөл шинэчлэх бичгийг Засаг даргад танилцуулан АДЗ-өө шинэчлэн гишүүдэд 2 дугаар сарын 26-ны өдөр зөвлөлийн гишүүдийн үүрэг,зөвлөлийн бүрэлдэхүүн,нийгмийн халамжийн ямар төрлүүдийг хэлэлцэн шийдвэрлэдэг талаар мөн нууцлалыг чанд хадгалах талаар хэлсэн.

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 8 удаа хийж шинээр асаргаа тогтоолгох-1,асаргаа сунгалт 8, ахмадын хүндэтгэл ,2021 онд амьжиргааг дэмжих 27 өрх сонгох,ОНОТХҮ-ий 1 бүлгийн төсөл,хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрт хамрагдах иргэдийн төслийг хэлэлцэн шийдвэрлэсэн. Сар шинийн баяраар 235 ахмадад 2350000 төгрөгийг хаан төрийн банкны дансаар олгосон.

Хүнсний эрхийн бичгийн мөнгөн дүн өөрчлөгдсөн талаарх мэдээлэлийг өгөн 1-5 сарын хүнсний эрхийн бичгийг олгоод байна. Хүнсний эрхийн бичгийн дэлгүүр сонгон шалгаруулах тендр,тендр цуцлагдсан талаар дэлгүүрүүдэд мэдээллийг тухай бүр хүргэн ажилласан. Хүнсний эрхийн бичгийн 42 өрхийн картыг төрийн банктай хамтран

коджуулсан. Насны хишиг алдарт эхийн одонгийн мөнгө олгохтой холбогдуулан алдарт эхийн одонтой, насны хишиг авах хүний дансыг Хаан ,төрийн банктай тулгалт хийн карттай дансыг холбох ажлыг хийж мөнгийг олгосон. Шинээр насны хишиг авах 12 иргэнийг праграммд мэдээллийг шивсэн.

Иргэн бүрт олгож байгаа 300,0 төгрөг ороогүй 124 хүний мэдээллийг ebaraimt 300 праграммд тулгалт хийх,Хаан, Төрийн банкуудтай тулгалт хийж мөнгө нь ороогүй иргэдтэй холбогдон дансгүй иргэдийг дансжуулах,ебаримт зөрчилтэй иргэдийн зөрчлийг арилган ажиллаж байна.

Сар бүр олголтын файлыг тулган мөнгийг олгож байна. Хүүхдийн мөнгөн тэтгэмжинд хамрагдах хүсэлт гаргасан 18 хүүхдийн өргөдлийг хүлээн авч мөнгийг олгосон. ОНОТХҮ-ий төсөлд 1 бүлгийн төсөл дэмжигдээд байна. Зорилтот 27 өрхөөс 1 өрхийн малжуулах хөтөлбөрт,ОНОТХҮ-ий төсөлд 1 өрх хамрагдсан. Төсөл хөтөлбөрүүд зарлагдсантай холбогдуулан сумын групп болон дэлгүүрүүдэд зар тавин 15 хүнд мэдээлэл өгөн 9 хүний төслийг хүлээн авсан. АДЗ-ийн гишүүдэд төсөл хөтөлбөрүүдийн танилцуулга мэдээллийг хийсэн.

Нийгмийн даатгал:

Сумын хэмжээнд нийт 21 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Шимтгэлийн орлогын төлөвлөгөөг оны эхнээс аж ахуй нэгж байгууллагуудад хувиарлан төлөвлөн сумын засаг даргаар батлуулан шимтгэлийг хуулийн хугацаанд оруулан ажиллаж байна. Эрүүл мэндийн даатгалын төлөвлөгөөг багуудад хувиарлан багийн дарга нартай гэрээ байгуулан ажиллаа .Гэрээний биелэлтийг хагас жилээр дүгнэн тамгын газарт тайлагнаж үүний үр дүнд:.

- Ажил олгогчийн шимтгэлд 178749,7 мян төг орохоос 231312,8 мян төг орж төлөвлөгөө 129,4%
- Сайн дурын даатгалд даатгуулагч 240 хамрагдахаас 163 даатгуулагч даатгаж, шимтгэлд 40504,6 төгрөгөөс 26200,6 мян төг орж 64,7%
- Эрүүл мэндийн даатгалын шимтгэлд 13989,2 мян төгрөг орохоос 9279,4 мян төгрөгийн шимтгэл орж 66,3 %тай тус тус биелэж нийт 233243,5 мян төг нийгмийн даатгалын шимтгэл орохоос 266792,8 мян төг-н шимтгэл орж нийгмийн даатгалын сангийн төлөвлөгөө 114,4% -р биелэлээ.
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэхээр 4 хүний материалыг хүлээн авч НДХэлтэсээр шалгуулан 9534,0 мян төгрөгийг шимтгэлийг төвлөрүүлэн аваад байна.

- нийт 1880878,5 мян төгрөгний тэтгэвэр, тэтгэмжийг сар бүр олгоод олголтын зөрчилгүй ажиллаж байна. Зарцуулагдаагүй сангийн үлдэгдлийг НДХэлтсийн ЭМДаатгалын санд- 40836,0 мян, ҮОШМӨ санд- 8276,0 мян, Ажилгүйдлын санд -2096,0 мян төгрөгийн шимтгэлийг 7 хоног бүр төвлөрүүлээд байна.

[illegible]

I ĨĪÐ-òýé òàìòðàí çîðēī āāēāóóēē áóé “Íýāā;ǎýýðð- ŌĹŊŲă” Ĵīāýñīēē ð°ā°ēā°īēē ðĴðýýīā 6-ð ñàðwí 01-īū °ā°ð àēīāēēī ðāàòðwí ðàðēī ðīāēīēòūā ñōīwí āðōīī īāēē ðóóāñāāð āàīæóóēài øýéðēýæ īēī īēéðýä ðĴǎýýñýī.

Öçüäëéí ààÿðûí çéë àèèèèääää çîðëíí áàèáóóèñàì òàèèàíã 6-ð ñàðûí 5-íú äìðîð áéíäèéí äÿð áçë
ðçöÿä çàèóó÷óóäûí ð°äèèèí äàçàðò òçðãçëñýí.

Эрүүл мэнд:

Үзлэгийн мэдээ 2021 оны 06 –р сарын 23 ны байдлаар

	Нэрс	Тоо
1	Урьдчилан сэргийлэх үзлэг	1154
2	Амбулаторийн үзлэг	851
3	Идэвхтэй хяналт	29
4	Гэрийн эргэлт	80
5	Гэрийн дудлага	106
6	Алсын дуудлага	82
7	Артерийн даралт	513
8	Чихрийн шижин	635
9	Хөхний үзлэг	263
10	Эсийн шинжилгээ	5
11	0-2 насны хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилга	103
12	Ковид-19 дархлаажуулалт вакцинд хамрагдсан	1-р тун-1764, 2-р тун 1538, Пейзер вакцин -16-17 нас, жирэмсэн, архаг хуучтай-72 иргэн хамрагдаад байна.
13	Түргэвчилсан тест	591
14	ПГУ шинжилгээ	233
15	Гэрийн тусгаарлалтад байгаа	25
16	Гэрийн ажиглалтад байгаа	0

Ерөнхий боловсролын сургууль :

- Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр сургуулийн дэргэдэх эцэг эхийн зөвлөлөөс, цахим мэндчилгээ дэвшүүлж, багш ажилчдынхаа хүүхдүүдийн дунд сугалаа зохион байгуулсан.
- ГБХЗХГ-т Сургуулийн дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн тайланг хугацаанд нь илгээсэн.

- Сургуулийн хашаа болон ногооны талбайд нийт 132 мод тарьж, арчилж тордож байна.
- Улаанбаатар хотын цэцэрлэгт хүрээлэнгийн магистр Мөнхбаяраас цэцэг арчилгаа, зүлэг тарих, хүлэмжид ногоо тарихад анхаарах зүйлийн талаар зөвлөмж зөвлөгөөг 10 багш, 13 ажилчдад авлаа.
- Сургуулийн гадна талбайд зүлэг тарьсан.
- Сургуулийн хашаанд цэцгийн 8 цэцгийн мандал тариад байна.
- Цар тахлаас урьдчилан сэргийлэх, хүүхдийн амралтын хугацаанд эцэг эхчүүдийн анхаарах зүйлийн талаар санамж зөвлөмжийг хүүхэд бүрд АУБ нар хүргээд байна.
- Бага ангийн 10 багш, сургалтын менежер нар “Байгалийн ухааны хичээлээр үнэлгээний даалгавар боловсруулах арга зүй” сургалтанд хамрагдаж байна.

Хүүхдийн цэцэрлэг:

1. Ковидтой холбогдуулан багш, ажилчид өөрийн хариуцсан анги танхимаа ариутгал халдваргүйтгэл болон их цэвэрлэгээ хийж хүлээлгэн өгөөд байна.
2. Багш. Ажилчдын амралт эхлэж байгууллага дээр нярав, жижүүр ажиллаж байна.
3. Байгууллагын цахим хуудасанд багш ажилчид хуваарийн дагуу “ковид19” зөвлөмж-5, зөвлөгөө-7 эрүүл ахуйн зөвлөмж-9, зөвлөгөө-6 байршуулаад байна.
4. Багш, ажилчид нийтийн эзэмшлийн талбайд тарьсан модоо өөр өөрсдөө услаж эргэж байна.
5. Байгуулгын халдвар хамгаалалын баг байгууллагынхаа дотор, гаднаа ариутгал халдваргүйтгалыг 2 удаа хийлээ.
6. Байгууллагын дээр хагас жилийн тооллого явагдаж байна.

Соёлын төв:

Тайлант хугацаанд манай байгууллагын ажилчид Ковид- 19 цар тахлын хорио цээрийн тахлын өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд хээрийн пост болон шуурхай штабын жижүүрийн үүргийг гүйцэтгэж ажиллаа.

Нийтийн номын сан цахим орчинд нутгийн ахмад үеийн тэргүүний малчдын туршлагаас цувралаар хүргэлээ. Мөн ардын аман зохиол, үлгэр, шилдэг бүтээлүүдээс толилуулж нийт 1054 хандалт авсан бна.

Соёлын өвийн үндэсний төв, ШУА-ийн түүх археологийн хүрээлэнгийн дэмжлэгтэйгээр” Титанс Пикчерс” ХХК-ийн –ийн санаачлан хэрэгжүүлж буй “”Монгол орны үзэсгэлэнт байгаль, түүхэн дурсгалтгазрууд” төслийн үйл ажиллагаанд хамтран оролцож өөрийн нутгийн байгаль, тахилга шүтлэгт уул, соёлын өв,түүх шастир, домог

хуучийг баримтжуулан ажиллаа. Тус үйл ажиллагааг ЗДТГ-аас хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж ИТХ-ын дарга Р.Анхбаяр, Засаг дарга Д.Амартайван нар тахилга шүтлэгт уул овооболон сум орон нутгийн мэдээлэл хийж оролцсон

СББӨ тээгч өндөр настан Ч.Даваа,Лантуу, Чулуу,Дорж, Дэчинчойнхорлон хийдийн хамба лам Д. Жигмэджамц нартай нутгийн домог, түүхийн талаар ярилцлага хийллгэв, Нийт 420 км замын маршрутаар Түүх соёлын үл хөдлөх дургалт 9 газар, тахилга шүтлэгт 3 уул, Байгалийн үзэсгэлэнт 10 газраар орж баримтат киноны зураг авалтыг хийлгэв. Түүх соёлын үл хөдлөх дурсгалуудад тандалт судалгаа хийх, 2 иргэнтэй гэрээ байгуулсан

Аймгийн Угсаатны зүйн музей,гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран иргэд олон нийтэд үндэсний уламжлалт өв соёлыг таниулах,нутгийн ончлогийг харуулсан марзайг өвлөн уламжлуулах, олон нийтэд сурталчлаххурдан морины уралдаанч хүүхэд багачуудыг алдаршуулах зорилгоор “Дарьганга марзай” цахим уралдааныг 2021.06.15-наас 2021.07.04-ийг хүртэл хугацаанд зарлаад байна.

Ахмадын дунд зохион байгуулсан “Ахмад 90” уралдаанд оролцож буй нийт 173 ахмадын бичлэгийг татан авч үзэн цахимаар шүүх ажилд хамтран оролцлоо.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Засаг даргын Тамгын газрын даргаар 2021 онд хэрэгжүүлэх Эрх зүйн ажлын төлөвлөгөөг 2021 оны 02 дугаар сарын 01-ний батлуулсан. Уг төлөвлөгөөний хэрэгжилт бүрэн гарсан төлөвлөгөөний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Аймгийн Засаг даргын 2016 оны А/80 дугаар захирамжийн дагуу сар бүрийн 1,11,21,31-нд архи, согтууруулах ундаа худалдахыг хориглосон мэдээллийн самбарыг буюу зурагт мэдээллийг нийтэд харуулж байршуулахыг аж ахуйн нэгж, байгууллагад үүрэг чиглэл өгч, цагдаагийн хэсэгтэй хамтарч хэрэгжилтэнд нь хяналт тавин ажилладаг. Хагас жилийн байдлаар дээрх захирамжийг зөрчсөн зөрчил илрээгүй байна. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн танилцуулгыг 2021 оны 06 дугаар сарын 01-ны өдөр Тамгын газрын албан ёсны цахим хуудсаар /Уулбаян сумын Засаг даргын Тамгын газар/ 2 удаа нийтлэхэд 400 хүнд хүрч, 10 хүн хуваалцсан, 5 хүнд таалагсан байна. 2021 оны 05 дугаар сарын 31-ны өдөр тус хуулийн хор уршгийг иргэд, олон нийтэд ойлгуулах, таниулах зорилгоор “Архи гэж юу вэ?”, “Архи уудаг хүмүүст юу

гэж хэлмээр байна“ гэсэн хүүхдийн үзэл бодлыг тусгасан бичлэгийг 75 хүнд хүрч, 3 хүн хуваалцаж, 3 хүнд таалагдсан байна. 2021 оны 06 дугаар сарын 01-ны өдөр бичлэгийг хүргэхэд 104 хүнд хүрч, 2 хүн хуваалцсан байна.

2. Даваа, Лхагва, Баасан гарагийг “Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн өдөр” болгон тус өдрөөс хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээллийг бэлтгэн, хуулийн танилцуулга хийж, мэдээлэл хүргэж байна. Тухайлбал, 2021 оны 04 дүээр сарын 16-наас эхлэн Гэр бүлийн тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Мал, хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг, Галын аюулгүй байдлын тухай хууль зэрэг нийт 10 хуулийн талаар мэдээлэл бэлтгэн цахим хуудсаар дамжуулсан.
3. 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр мэдээллийн цагт www.e-khutuch.mn цахим хуудасны тухай, хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл авах боломжтой талаар ажилтан, албан хаагчдад анх танилцуулсан. Мөн 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдөр шинээр томилогдсон багийн Засаг дарга нар, ажилтан албан хаагчдад мэдээлэл хүргэсэн. Эрх зүйн хөтөч цахим хуудсыг ЗДТГ-н цахим хуудаснаас 2021 оны 03 сарын 15-ны өдөр танилцуулж, нийтэд мэдээллэсэн.
4. 2021 оны 02-06 дугаар сарын хугацаанд захирамж-31, тушаал-5, Мэдэгдэл-1, албан тоот-3, гэрээ-2 тус тус боловсруулж, хянасан байна. Эдгээрийн эрх зүйн үндэслэлийг хуульд нийцүүлэн баримталсан болно. Мөн мэргэжилтэн бүр захирамж, тушаал, аливаа эрх зүйн баримт бичиг төлөвлөхдөө хууль, эрх зүйн мэргэжилтнээр эрх зүйн үндэслэлийг хянуулж албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж байна.
5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн танилцуулгыг аудио, бичлэг, зурагт хэлбэрээр ЗДТГ-н албан ёсны цахим хуудаснаас нийт 8 удаа сурталчилсан байна. Засаг даргын Тамгын газраас Даваа, Лхагва, Баасан гарагийг “Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн өдөр” болгон зарлаж, 2021 оны 04 дүээр сарын 16-наас эхлэн мэдээлэл хүргэж эхэлсэн. Тухайлбал, 2021.04.17-ны өдөр тус 1 удаа мэдээлэл хүргэхэд 79 хүнд хүрч, 1 хүнд таалагдсан, 2 хүн хуваалцсан байна. 2021.05.02-ны өдөр нийтлэхэд 35 хүнд хүрч, 11 хүн хуваалцсан байна. 2021.05.31-ны өдөр 3 удаа нийтлэхэд 2936 хүнд хүрч, 44 хүн хуваалцсан, 2 хүн таалагдсан. 2021.06.01-ны өдөр 3 удаа нийтлэхэд 453 хүнд хүрч, 5 хүн хуваалцсан, 1 хүнд таалагдсан байна.

Хууль тогтоомжийн лавлагааны сан бүрдүүлж, хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар мэдээлэл цуглуулж, шинээр хавтас үүсгэн.

- Батлагдсан хууль, дагаж мөрдөх, дагаж мөрдөх журмы тухай хууль, нэмэлт орсон, өөрчлөлт оруулсан гэх зэргээр ангилан хүснэгт үүсгэсэн. Тухайлбал, 2020 онд батлагдсан ний 33 хууль байгаа бөгөөд 2021.01.01-ээс хэрэгжиж эхэлсэн 4 хууль байна. 2022 оноос эхлэн хэрэгжиж эхлэх 1 хууль байна
- 2020 онд батлагдсан дагаж мөрдөх журмын тухай хууль 8 бөгөөд 2021 оноос эхлэн дагаж мөрдөх хууль 1 байна.
- 2019 онд батлагдсан 4 хуульд өөрчлөлт оруулсан-2, нэмэлт оруулсан-2 зүйл байна. 2020 онд батлагдсан 9 хуульд өөрчлөн найруулсан - 3, нэмэлт оруулсан- 4, нэмэлт, өөрчлөлт оруулсан-2 тус тус зүйл байна.
- 2021 онд батлагдсан 1 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан-1 зүйл байна

ЗДТГ-н мэргэжилтэн нараас өөрсдийн чиг үүргийн дагуу хууль зүйн сурталчилгаа хийсэн талаар:

1. **Нийгмийн даатгалын байцаагч** - Нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлт, сайн дурын даатгал, малчин-даатгуулагчийн тэтгэврийн даатгалын хуулийг хэрэгжүүлэх зорилгоор сурталчилгааны ажлын төлөвлөгөө гарган сумын Засаг даргаар батлуулан ажиллаж байна. Ажлын байранд 96 иргэнд малчин даатгуулагчийн тэтгэврийн хуулиар зөвлөгөө өгч, тэтгэвэр тогтоох материалын бүрдлийг шалган 26 иргэний материалын дутууг хэрхэн бүрдүүлэх талаар тайлбарлан зөвлөгөө өгч, Засаг даргын дэргэдэх даатгуулагчийн малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөл нь 3 удаа хуралдаж 7 иргэний нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг малчнаар ажмлласнаар тодорхойллоо. Тус хугацаанд 649 иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүлсэн. Иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх тэдний сэтгэл ханамжийг дээшлүүлэх цахимаар хэрхэн шимтгэл төлөх, цар тахлын үед тэтгэвэр, тэтгэмжийг хэрхэн тогтоох олгох талаар онлайн сургалт бэлтгэн 5 группэд түгээлээ.
2. **Иргэний улсын бүртгэгч** – 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдөр “Уулбаян сумын Улсын бүртгэл” цахим хуудас нээсэн бөгөөд 109 гишүүнтэй, 23 төрлийн улсын бүртгэлтэй холбоотой мэдээ, мэдээлэл, зарыг давхардсан тоогоор 847 иргэнд хүргэж, танилцсан байна.
3. **Татварын улсын байцаагч** – 2020 онд батлагдаж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн “Малын тоо, толгойн албан татвар”-ын тухай хуулийн танилцуулгыг ИТХ, ЗДТГ-н нийт албан хаагчдад танилцуулж, цахим хэлбэрээр сурталчилсан.

- 4. Хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн-** Эрх зүйн ажлын төлөвлөгөөнөөс гадна архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийг судалсан. Тухайлбал, 1998 оны Архивын тухай хуулийг 2020 онд хүчингүй болгосон бөгөөд 2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдөр батлагдсан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийг 2020 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Тус хуулийг судлах хүрээнд 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Төрийн албаны болон архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилт сургалтад ЗДТГ-н дарга, Архив, бичиг хэргийн ажилтан, Хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн, Төсөвт байгууллагын архив, бичиг хэргийн ажилтан нар хамрагдсан.
- 5. Эрх бүхий албан тушаалтан** - 2021 оны 02 дугаар сард Төрийн удирдах албан тушаалтан, ИТХ-ын төлөөлөгч нарт Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, Хөрөнгө орлогын мэдүүлгээ цахимаар яаж мэдүүлэх, хамаарал бүхий этгээдийн тухай тайлбар, мэдэгдэл, Авилгын эсрэг хуулийн талаар сургалт зохион байгуулж хууль, гарын авлага тарааж ажилласан.

Сумын Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх төсөл хөтөлбөр, 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө зэргийг батлуулахад иргэдийн саналыг цахим хэлбэрээр, байгууллага, төрийн хаагчдын саналыг бичгийн хэлбэрээр авч, оролцоог нь хангаж, шийдвэртээ тусгасан.

Иргэдээс ирүүлэх өргөдөл, гомдол, санал хүсэлт, мэдээллийг түргэн шуурхай хүлээн авч, шийдвэрлэх зорилготой тусгай дугаарын 98514040 дугаарыг 2013 оноос эхлэн ажиллуулж байгаа бөгөөд 2021 оны эхний хагас жилийн байдлаар тус дугаарт нийт 23 өргөдөл, гомдол хүлээн авч, шийдвэрлэсэн байна.

Засаг даргын тамгын газраас долоо хоногийн 1, 3, 5 дахь өдрийг “Хууль зүйн зөвлөгөө мэдээллийн өдөр” болгосон бөгөөд өөрсдийн болон бусад төрийн байгууллагын бэлгэтсэн хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн эх сурвалжийг дурдаж мэдээллийг “Уулбаян сумын Засаг даргын Тамгын газар” гэсэн цахим хуудсаар тогтмол хүргэж байна. 2021 оны эхний хагас жилийн байдлаар 20 удаагийн хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээллийг нийт давхардсан тоогоор 10800 хүнд хүргэсэн байна.

Төрийн байгууллагын үйл ажиллагааг ил тод нээлттэй байлгах үүднээс коронавируст халдвар болон цаг үеийн мэдээллийг “Сүхбаатар аймгийн Уулбаян сумын албан ёсны мэдээ, мэдээллийн нэгдсэн групп”, “Уулбаян сумын Засаг даргын Тамгын газар” цахим хуудас нээн түүгээр хүргэж байна.

Тамгын газрын албан хаагчдыг долоо хоног бүрийн дөрөв дэх өдрийн мэдээллийн цагт долоо хоногт хийсэн ажил, цаашид хийх зүйлийн тухай үргэлжүүлэн илтгэл тавьж байна..

Төрийн албаны хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад Тамгын газрын дарга, Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн нар 04 дүгээр сараас эхлэн суралцаж 06 сард амжилттай төгссөн.

“Засгийн газрын хэрэг эрхлэх газраас аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга нарын нэгдсэн уулзалтын хүрээнд даалгасан ажлыг орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2021 оны 04 дүгээр сарын 21-ны өдөр Засаг даргаар батлуулсан. Тус төлөвлөгөөний дагуу Тамгын газрын албан хаагчдын захирамж, тушаал, шийдвэр боловсруулсан албан хэрэг хөтлөлтийн байдалд үзлэг хийж, шалгалтыг хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн хариуцан зохион байгуулж, дүгнэл гаргаж, түүний биелэлтийг гаргасан.

Хууль, эрх зүйн сургалт, сурталчилганы тайланг 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдөр ТЗУХ-т хүргүүлсэн. Үүнээс гаднах, цаг үеийн асуудлаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлийг хугацаанд нь хүргүүлсэн байна. Мөн Сумын хэмжээнд бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг боловсруулж, захирамж гаргасан байна

Улсын Онцгой Комиссын даргын 2021 оны 03 сарын 03-ний өдрийн 18 дүгээр тушаалын хэрэгжилтийн биелэлтийг ханган ажиллаж байна. Үүнд:

1. “Ковид-19”-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах түүнд тавигдах шаардлагуудыг чиглэл чиглэлээр ангилж аж ахуйн нэгж, иргэнд хүргэж ажилласан.
2. Аж ахуйн нэгж, байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэнд “Амны хаалт тогтмол зүүх”, “Маскгүй хүнд үйлчлэхгүй” гэсэн шаардлагыг тавьж ажилласан.
3. “Эрдэнэ-Оргих”, “Дэлгэр”, “Хишиг” гэсэн 3 аж ахуйн нэгжид “Зай барих”, “Амны хаалт зүүх”, тэмдэг зөвлөгөөг гарган өгч лангуу, хаалга мэдээллийн самбар дээр байрлуулсан.
4. Иргэн бүрийг өөрийн болон гэр бүлийн гишүүдээ болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж, QR код уншуулах, амны хаалт зүүж, хоорондын зайгаа барьж үйлчлүүлэх, нийтийг хамарсан арга хэмжээнд оролцохгүй байхыг зөвлөж байна.

Сумын Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/44 дүгээр захирамжаар “Гэрийн тусгаарлалт, ажиглалад байгаа иргэдэд хяналт тавих ажлын хэсэг” байгуулан хэсгийн ахлагчаар хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн ажиллаж байна. Тус ажлын хэсэг нь гэрийн тусгаарлалт, ажиглалтад байгаа иргэдэд зөвлөмж, баталгаажилтын хуудас, хууль, дүрмийг бэлтгэн өгч, өдөр бүр ярьж биеийн байдлыг үзэж байна. Өнөөдрийн байдлаар гэрийн тусгаарлалт-25 иргэн, гэрийн ажиглалтад иргэн байхгүй байна.

2021 оны эхний хагас жилийн байдлаар тусгай дугаарын /98514040/ утсаар 23 иргэний санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

2021 оны 06 сарын байдлаар Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг-1, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих-7, танхайрах-1 тус тус гэмт хэрэг, зөрчил гарсан байна.

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ, ЭРХ ҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Л.ДАШБАЛЖИННЯМ